

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/20/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СХЗГ	Стандарт Хэмжил зүйн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.14 № 01/47
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.БАТСАЙХАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан ажилчдын дотоод нөөц боломжид тулгуурлан “Стандарт-50” нэртэй төгөл байгуулж, хэлтсийн барилгын үүдэнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэргэнцрийн зам, гадна гэрэлтүүлэг болон хяналтын камерыг байршуулах зэрэг ажлууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

- Үйл ажиллагааны орлогыг харилцагч тус бүрээр болон аккрузл сууриар бүртгэдэггүй байна.
- Зарим худалдан авалтууд цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,957,064.00	7,159,944.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,957,064.00	7,159,944.00
351	Түүхий эд материал	5,368,408.00	5,298,838.00
35110	Тусгай зориулалттай материал	5,243,908.00	5,294,038.00
35130	Эм боох материал	124,500.00	4,800.00
354	Хангамжийн материал	4,588,656.00	1,861,106.00
35410	Бичиг хэргийн материал	309,900.00	385,700.00
35420	Аж ахуйн материал	2,389,756.00	1,420,406.00
35440	Түлш, шатах тослох материал	705,000.00	55,000.00
35450	Барилгын засварын материал	1,184,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	104,671,280.88	125,749,782.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	104,671,280.88	125,749,782.20
392	Биет хөрөнгө	83,431,280.88	104,509,782.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	85,363,236.00	85,363,236.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12,421,736.28	-23,092,140.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,800,000.00	14,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,250,000.20	-11,716,666.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	59,327,535.00	48,777,918.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,709,934.72	-9,873,874.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,328,978.00	6,183,701.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,006,796.92	-5,932,390.36
393	Биет бус хөрөнгө	21,240,000.00	21,240,000.00
39301	Програм хангамж	500,000.00	500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-500,000.00	-500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	21,240,000.00	21,240,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	114,628,344.88	132,909,726.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	28,850.04	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	28,850.04	00.00
413	Өглөг	28,850.04	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	28,850.04	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	114,599,494.84	132,909,726.20
51	Засгийн газрын хувь оролцоо	114,599,494.84	132,909,726.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	130,292,927.00	130,292,927.00
51101	Өмч: - төрийн	130,292,927.00	130,292,927.00
512	Хуримтлагдсан үр дүн	-68,466,435.16	-50,156,203.80
51210	Өмнөх үеийн үр дүн	-68,466,435.16	-68,466,435.16
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	18,310,231.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	52,773,003.00	52,773,003.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	114,628,344.88	132,909,726.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	278,563,076.00	237,532,727.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	145,390,876.00	127,014,327.00
120	Нийтлэг татварын бус орлого	145,390,876.00	127,014,327.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	145,390,876.00	126,797,747.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,142,920.00	90,755,093.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	55,247,956.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	133,172,200.00	110,518,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	133,172,200.00	110,518,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	133,172,200.00	110,518,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	231,199,909.92	219,222,495.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	231,199,909.92	219,222,495.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	203,196,489.59	211,449,264.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,425,159.43	135,751,791.55
210101	Үндсэн цалин	105,151,806.83	104,818,566.00
210102	Нэмэгдэл	31,516,141.60	25,830,940.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,757,211.00	3,658,496.88
210104	Урамшуулал	00.00	1,443,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,216,462.44	16,646,208.98
210201	Тэтгэврийн даатгал	12,790,062.00	11,381,906.44
210202	Тэтгэмжийн даатгал	1,424,066.99	1,339,047.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,119,094.45	1,071,238.41
210204	Ажилгүйдлийн даатгал	262,113.24	259,455.87
210205	Эрүүл мэндийн даатгал	2,621,125.76	2,594,560.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,582,653.29	17,428,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,070,663.29	1,053,963.50
210302	Түлш, халаалт	14,897,520.00	14,834,936.50
210303	Цэвэр, бохир ус	1,614,470.00	1,539,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,615,938.55	9,060,370.00
210401	Бичиг хэрэг	1,101,600.00	1,254,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,781,500.00	3,558,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,740,908.55	2,417,370.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	751,930.00	655,900.00
210408	Бараа материал ақталсны зардал	00.00	935,000.00
2105	Нормативт зардал	294,200.00	483,700.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	294,200.00	483,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,670,870.00	1,338,595.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	535,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	640,000.00	595,200.00
210604	Урсгал засвар	2,030,870.00	208,395.00
2107	Томилолт, зочны зардал	4,940,000.00	4,920,000.00
210702	Дотоод албан томилолт	4,940,000.00	4,920,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,962,016.00	2,703,898.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	369,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	294,068.00	256,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,928.00	34,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	320,000.00	253,000.00
210807	Газрын төлбөр	63,720.00	63,720.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,795,300.00	1,703,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,489,189.88	23,116,101.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	943,400.00	8,101,948.46
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	714,500.00	50,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,831,289.88	14,964,152.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,003,420.33	7,773,230.97
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	2,217,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	2,217,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	560,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,556,230.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,556,230.97
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,443,420.33	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,443,420.33	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	47,363,166.08	18,310,231.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	223,315,120.00	201,273,493.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	90,142,920.00	90,755,093.00
120	Нийтлэг татварын бус орлого	90,142,920.00	90,755,093.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	90,142,920.00	90,755,093.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,142,920.00	90,755,093.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	133,172,200.00	110,518,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	133,172,200.00	110,518,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	133,172,200.00	110,518,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	223,315,120.00	201,273,493.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	223,315,120.00	201,273,493.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,311,699.67	193,500,262.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	140,396,316.60	135,751,791.55
210101	Үндсэн цалин	105,122,964.00	104,818,566.00
210102	Нэмэгдэл	31,506,852.60	25,830,940.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,766,500.00	3,658,496.88
210104	Урамшуулал	00.00	1,443,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,216,455.23	16,646,208.98
210201	Тэтгэврийн даатгал	12,790,056.18	11,381,906.44
210202	Тэтгэмжийн даатгал	1,424,066.93	1,339,047.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,119,093.68	1,071,238.41
210204	Ажилгүйдлийн даатгал	262,112.46	259,455.87
210205	Эрүүл мэндийн даатгал	2,621,125.98	2,594,560.48

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,582,653.29	17,428,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,070,663.29	1,053,963.50
210302	Түлш, халаалт	14,897,520.00	14,834,936.50
210303	Цэвэр, бохир ус	1,614,470.00	1,539,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,166,138.55	7,463,820.00
210401	Бичиг хэрэг	1,308,900.00	1,276,900.00
210402	Тээвэр, шатахуун	3,050,000.00	2,908,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,740,908.55	2,417,370.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	826,330.00	621,550.00
2105	Нормативт зардал	418,700.00	364,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	418,700.00	364,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,414,620.00	2,003,595.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	665,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	640,000.00	595,200.00
210604	Урсгал засвар	774,620.00	743,395.00
2107	Томилолт, зочны зардал	4,940,000.00	4,920,000.00
210702	Дотоод албан томилолт	4,940,000.00	4,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,721,716.00	2,391,628.00
210802	Аудиг, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	397,800.00	369,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	294,068.00	256,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	34,928.00	34,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	275,000.00	253,000.00
210807	Газрын төлбөр	63,720.00	63,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	34,200.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	600,000.00	1,382,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,455,100.00	6,530,618.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,430,600.00	5,917,618.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,024,500.00	613,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,003,420.33	7,773,230.97
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	2,217,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	2,217,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	560,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	560,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	5,556,230.97
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	5,556,230.97
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,443,420.33	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,443,420.33	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,292,927.00	52,773,003.00	-115,648,659.24	00.00	67,417,270.76
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,292,927.00	52,773,003.00	-115,648,659.24	00.00	67,417,270.76
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	47,363,166.08	00.00	47,363,166.08
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,292,927.00	52,773,003.00	-68,466,435.16	00.00	114,599,494.84
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,292,927.00	52,773,003.00	-68,466,435.16	00.00	114,599,494.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	130,292,927.00	52,773,003.00	-68,466,435.16	00.00	114,599,494.84
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	18,310,231.36	00.00	18,310,231.36
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	130,292,927.00	52,773,003.00	-50,156,203.80	00.00	132,909,726.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	199,410,400.00	193,500,262.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	198,889,600.00	193,500,262.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	198,889,600.00	193,500,262.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	137,408,300.00	135,751,791.55
210101	Үндсэн цалин	105,364,900.00	104,818,566.00
210102	Нэмэгдэл	27,885,400.00	25,830,940.67
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,158,000.00	3,658,496.88
210104	Урамшуулал	-	1,443,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,176,100.00	16,646,208.98
210201	Тэтгэврийн даатгал	11,679,700.00	11,381,906.44
210202	Тэтгэмжийн даатгал	1,374,100.00	1,339,047.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,099,300.00	1,071,238.41
210204	Ажилгүйдлийн даатгал	274,800.00	259,455.87
210205	Эрүүл мэндийн даатгал	2,748,200.00	2,594,560.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,428,600.00	17,428,600.00
210301	Гэрэл, цахилгаан	1,360,500.00	1,053,963.50
210302	Түлш, халаалт	14,528,400.00	14,834,936.50
210303	Цэвэр, бохир ус	1,539,700.00	1,539,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,664,500.00	7,463,820.00
210401	Бичиг хэрэг	1,324,400.00	1,276,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,908,000.00	2,908,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,383,300.00	2,417,370.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	257,500.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	791,300.00	621,550.00

2105	Нормативт зардал	400,400.00	364,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	400,400.00	364,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,269,200.00	2,003,595.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	930,000.00	665,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	595,200.00	595,200.00
210604	Урсгал засвар	744,000.00	743,395.00
2107	Томилолт, зочны зардал	5,704,100.00	4,920,000.00
210702	Дотоод албан томилолт	5,704,100.00	4,920,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,736,900.00	2,391,628.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	369,900.00	369,900.00
210803	Даатгалын үйлчилгээ	473,000.00	256,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,500.00	34,928.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,800.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	292,900.00	253,000.00
210807	Газрын төлбөр	63,200.00	63,200.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	18,600.00	10,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,382,000.00	1,382,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,101,500.00	6,530,618.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,295,600.00	5,917,618.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	805,900.00	613,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	520,800.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	520,800.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	520,800.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	190,518,400.00	201,273,493.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	110,518,400.00	110,518,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	110,518,400.00	102,745,169.03
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	80,000,000.00	90,755,093.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	88,892,000.00	90,755,093.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	14.00	14.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь тус аймгийн нутаг дэвсгэрт Монгол Улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэх эрхэм зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг, Стандарт, Хэмжил зүйн газарт санхүүгийн тайлангаа нэгтгүүлдэг, Монгол улсын Шадар сайдын харьяа байгууллага юм.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний баталгаажуулалт хийж, тохирлын гэрчилгээ олгох
- Хэмжих хэрэгсэл, хэмжүүр баталгаажуулалтыг хүндийн хэмжил, цахилгаан соронзонгийн хэмжил, эзлэхүүн багтаамж хийн шингэний зарцуулалтын хэмжээ
- Стандарт мэдээлэл, лавлагааны үйлчилгээ үзүүлж, салбар сан үүсгэн стандартыг цахим хэлбэрээр хадгалах
- Сорьцын хяналт тавих

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 24 арга хэмжээтэй баталснаас нийт 94.8%-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Хэмжил зүйн тухай хууль
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Стандарт Хэмжил Зүйн хэлтсийн даргын 2018 оны 03 сарын 19-ний А/06 тоот Байгууллагын Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах ажлын хэсгийг шинэчлэн томилох тухай тушаал гарсан. Тушаалын хавсралтаар /SHZH 41009: 2017/ стандартын дагуу Дотоод

хяналт, шалгалтыг хийх журам батлагдсан. 2022 онд хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу 3 удаа дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан ажилласан байна.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэст аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албаас хяналт шалгалт хийгдэж 1,735.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоосон байна.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Стандарт Хэмжил зүйн газраас 2020 онд баталсан шинэчилсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,281.4 мянган төгрөгөөр буюу 15.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	9,957.0	7,159.9	-2,797.1
Үндсэн хөрөнгө	104,671.2	125,749.7	21,078.5
Нийт хөрөнгө	114,628.3	132,909.7	18,281.4
Өр төлбөр	28.8	0.0	-28.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	114,599.5	132,909.7	18,310.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	114,628.3	132,909.7	18,281.4

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд бараа материал дансны эхний үлдэгдэл 9,957.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 7,159.9 мянган төгрөг болж нэмэгдсэн болон хасагдсан бараа материалын зөрүү 2,797.1 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд 935.0 мянган төгрөгийн бараа

материал данснаас акталж хасан байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 104,671.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 125,749.7 мянган төгрөг болж, 21,078.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нэмэгдсэн болон хасагдсан үндсэн хөрөнгөөс гадна элэгдлийн зардалтай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 132,909.7 мянган төгрөг болж 18,310.2 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Мөнгөн хөрөнгө, авлага данс эхний, эцсийн үлдэгдэлгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 169,054.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 73,135.0 мянган төгрөг, нийт 269,189.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсээс дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 78,903.4 мянган төгрөгөөр бууруулан 2022 оны урсгал зардлын төсвийг 192,285.9 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн.

Энэ нь 2022 оны төсвийн төслөөс хөрөнгө оруулалтын зардлыг хасаж баталснаас шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 192,285.9 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 201,273.4 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 110,518.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 90,755.0 мянган төгрөг, нийт 201,273.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 7,773.2 төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 193,500.2 мянган төгрөг буюу 97.0 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, албан томилолтын зардал, бараа үйлчилгээний бусад зардлуудыг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70407/80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	200,752.6	193,500.2	7,252.4	96.4%
2	70407/80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	520.8	0.0	520.8	0.0%
	ДҮН	201,273.4	193,500.2	7,773.2	96.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70407	2022.01.01-2022.12.31	Стандартчилал хэмжил зүй	Хөтөлбөр 94.8%	199,410.4	193,500.2

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Улсын ерөнхий Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн батлагдсан 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 278,563.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 4,178.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,133.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтэст авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13 орлогын мөнгөн гүйлгээг мэдээлсэн ба өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэр гараагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 6 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 4 зөвлөмж хэрэгжсэн, 2 зөвлөмж хэрэгжээгүй тул аудитын тайланд зөрчлөөр оруулсан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 40 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	705.0	1	705.0	100%
Зөвлөмж	3	2,425.7	3	2,425.7	100%
Нийт дүн	4	3,130.7	4	3,130.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Стандарт, Хэмжил зүйн хэлтсийн дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 895.5 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд 2 зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үйл ажиллагааны орлогыг харилцагч тус бүрээр, тухай бүр бүртгэдэггүй, мөн аккрузл сууриар бүртгэж авлага үүсгэдэггүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид орлогыг аккрузл сууриар бүртгэж ажиллах.

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг цахим төлбөрийн баримттай тулгалт хийхэд цахим төлбөрийн баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 895.5 мянган төгрөгөөр дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид худалдан авалт бүрийг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулах, худалдан авах гэрээнд цахим төлбөрийн баримт авах талаар тусгах, тухай бүр хяналт тавьж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Худалдан авалт цахим төлбөрийн баримтаар баталгаажаа гүй.	2	895.5					2	895.5				
Дүн	1	895.5					1	895.5				